



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 384

Улаанбаатар хот

Г Зөвшөөрөл олгох тухай Г

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.5 дахь заалт, “Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2019 оны 18 дугаар тогтоол, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоол, Сонгуулийн ерөнхий хорооны 2006 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Ажлын албаны ажиллах журам”-ын 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг хянан хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг хавсралт ёсоор батлахыг тус Хорооны дарга /Ч.Содномцэрэн/-д зөвшөөрсүгэй.

2. Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт тус бүрийг албажуулах, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Ажлын алба /Б.Алтанзул/-нд даалгасугай.

ДАРГА

Б.БААТАРЗОРИГ





МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 30 өдөр

Дугаар A/19

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоол, “Зөвшөөрөл олгох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 384 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Сонгуулийн Ерөнхий Хорооны Ажлын албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг хавсралт ёсоор баталсугай.
- Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлагдсантай холбоотойгоор холбогдох журмын дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Б.Маймэнх/-д даалгасугай.

ДАРГА Ч. СОДНОМЦЭРЭН

Ч.СОДНОМЦЭРЭН



**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 385

Улаанбаатар хот

Г Зөвшөөрөл олгох тухай Т

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.5 дахь заалт, “Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2019 оны 18 дугаар тогтоол, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтуудын албан тушаалын тодорхойлолтыг хянан хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Ахлах референтын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Референтын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Ахлах шинжээчийн албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Шинжээчийн албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Мэдээлэл, судалгаа, арга зүйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Ахлах референтын албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Референтын албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Ахлах шинжээчийн албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Шинжээчийн албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар хавсралт, Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Ахлах референтын албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Референтын албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Ахлах шинжээчийн албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр хавсралт, Шинжээчийн албан тушаалын тодорхойлолтыг 15, 16 дугаар хавсралт ёсоор тус тус батлахыг Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга /Д.Баяндүүрэн/-д зөвшөөрсүгэй.

2. Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт тус бүрийг албажуулах, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Б.Алтанзул/-нд даалгасугай.

ДАРГА

Б.БААТАРЗОРИГ



ТАЗ тогтоол 2019

. 19000561



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 115


Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоол, "Зөвшөөрөл олгох тухай" Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 385 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгуулийн Ерөнхий Хорооны Ажлын албаны Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Ахлах референтийн албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Референтийн албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Ахлах шинжээчийн албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Шинжээчийн албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Мэдээлэл, судалгаа, арга зүйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Ахлах референтийн албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Референтийн албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Ахлах шинжээчийн албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Шинжээчийн албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Ахлах референтийн албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Референтийн албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Ахлах шинжээчийн албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр, Шинжээчийн албан тушаалын тодорхойлолтыг 15, 16 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлагдсантай холбоотойгоор холбогдох журмын дагуу зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Б.Маймөнх/-д даалгасугай.



ДАРГА

Д.БАЯНДҮҮРЭН